Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Нийтийн номын сангийн "Дотоод хяналтын ажлын хэсэг"-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тайлант онд дотоод хяналтын ажлын хэсэг дараах ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн. Үүнд:

1. Номын санд шинээр худалдан авсан болон хандиваар ирсэн ном хэвлэлээр фонд баяжилт хийж шинээр авсан номыг электрон каталогт оруулах
2. Ном алдаж үрэгдэхээс урьдчилан сэргийлж "Гэрээр олгох танхим"-ын номыг тоолж электрон каталог, нэг бүрчилсэн бүртгэлтэй тулгалт хийх
3. Номын сан нь барилгын засвар шинэчлэл хийгдэж чөлөөт уншлагын танхимуудтай болохтой холбогдуулан сандал ширээ, тавилга, номын тавиурыг нүүлгэн шилжүүлэх, үсэг дараалал болон төрөл ангийн номуудыг гурван уншлагын танхимуудад байрлуулах ажлыг хийж хэрэгжүүлэн ажиллах
4. Номын сангийн үйл ажиллагааг уншигч үйлчлүүлэгчдэд нээлттэй хүргэх зорилгоор өөрийн байгууллагын [www.library.to.gov.mn](http://www.library.to.gov.mn) цахим хуудас, Page хуудас, мэдээллийн самбарт мэдээллийн санг тухай бүр баяжуулж үйл ажиллагаагаа тогтмол сурталчлах
5. Төсөв санхүүг зориулалтын дагуу өр авлага үүсгэхгүй зарцуулж, мэдээ тайланг цаг хугацаанд нь өгч ажиллан шилэн дансны хуулийг хэрэгжүүлж батлагдсан төсөв, гүйцэтгэлийг ил тодоор байрлуулан хэрэгжилтийг тухай бүр гаргах
6. Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг тухай бүр иргэд олон нийтэд мэдээлж байх
7. Номын сангийн уншлагын танхимын номын санчид үйлчилгээний хүртээмжийг сайжруулж шинэлэг ажлыг бүтээлчээр зохион байгуулах
8. Иргэдийн цахим хуудсанд хандсан санал хүсэлт, нээлттэй утас, санал хүсэлтийн хайрцаг болон дэвтэр, татгалзлын дэвтэр зэргийг тогтмол ажиллуулж хяналт тавих чиглэлээр ажиллаж, улирал бүр байгууллагын удирдлагад тайлагнаж ирсэн байна.

Төв аймгийн Нийтийн номын сангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг. 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нийтийн номын сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 5,763.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,611.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлаас 2.0 хувиар буюу 5,434.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 4,347.4 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 263.6 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Нийтийн номын сан нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “ аcolous ” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

#### **Орлого:**

Төв аймгийн Нийтийн номын сан нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 245,531.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,352,784.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 7,858.2 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 1,606,174.6 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 245,531.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд

бусад орлого 7,858.2 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 253,390.1 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Соёлын сайдын А/150 тоот тушаалаар 1,250.0 мянган төгрөг, Баяндэлгэр сумын ЗДТГ-с 750.0 мянган төгрөг, Нумт Өргөө ХХК-с ашиглалтын зардалд 4,047.0 мянган төгрөг, Билгүүн Ганболдоос заалны 1.5 өдрийн түрээсийн 150.0 мянган төгрөг, хандиваар 1,400.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө борлуулсны орлого 68.0 мянган төгрөг, карт нээсний орлого 193.2 мянган төгрөг, нийт 7,858.2 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

### **Зардал:**

Төв аймгийн Нийтийн номын сан нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар 271,713.0 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 253,390.1 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100140035011 тоот дансанд 245,531.9 мянган төгрөгийн орлого, 245,531.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140035403 тоот дансанд 7,858.2 мянган төгрөгийн орлого, 7,858.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

### **Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 981,675.4 мянган төгрөг, тайлант онд үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор 11 иргэн ААНБ-аас 1,354,940.5 мянган төгрөгийн барилга, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, ном үнэ төлбөргүй шилжүүлэн орлого авч, 5 байгууллагаас 3,826.0 мянган төгрөгийн ном, принтер худалдан авсан байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 22,682.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 19,519.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 42,201.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устган, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,294,414.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 8,500.3 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 6788.5 мянган төгрөг, ЭБЭТ ХХК-с үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 1,670.0 мянган төгрөг, нийт 8,458.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 7,195.4 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 9,763.4 мянган төгрөг байна.

### **Авлага, өглөгийн талаар:**

Тайлант жилийн авлагын дансны эхний үлдэгдэл 0 төгрөг, авлага нэмэгдсэн 1,329.3 мянган төгрөг, хасагдсан 1,329.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 271,949.4 мянган төгрөг, хасагдсан 271,949.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 12 байгууллагуудтай тооцооны дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

### Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 9,763.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,187,193.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	8,500.3	9,763.4	1,263.1
Үндсэн хөрөнгө	853,994.6	2,187,193.1	1,333,198.5
Нийт хөрөнгө	862,494.9	2,196,956.5	1,334,461.6
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	862,494.9	2,196,956.5	1,334,461.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	862,494.9	2,196,956.5	1,334,461.6

Бараа материалын дансны үлдэгдэл 9,763.4 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 1,263.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал дансанд лед гэрэл, гадна буун гэрэл хүлээж авсан нь жилийн эцсийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,187,193.1 мянган төгрөг болж 1,333,198.5 мянган төгрөгөөр өсөхөд 2020 онд Төв аймаг-БНСУлсын Пёнтек хотын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Нийтийн номын санг Солонгос улсын Пёнтек хотоос 920,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 276,000.0 мянган төгрөг, нийт 1,196,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар номын санд засвар шинэчлэл хийж, зураг төслийг ДИ ЭС ЖИ ХХК хийж, гүйцэтгэгч компаниар НУМТ ӨРГӨӨ ХХК шалгарч, их засварын ажил 100 хувийн гүйцэтгэгдэж орлого авсан нь голлох нөлөөллийг үзүүлж байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 21,742.0 мянган төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 42,201.9 мянган төгрөг байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 2,196,956.5 мянган төгрөг болж, 1,334.461.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 295,616.0 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөн, нийт урсгал зардалд 295,616.0 мянган төгрөг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 50,404.1 мянган төгрөгөөр бууруулан орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 245,211.9 мянган төгрөг, урсгал зардлыг 245,211.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур төлөвлөгөөнд тодотгол хийгдэж, 320.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 245,531.9 мянган төгрөгийн төсөв зарцуулах эрх нээгдсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 245,531.9 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн авч, 241,424.4 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 4,107.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт урсгал зардлын гүйцэтгэл 241,424.4 мянган төгрөг буюу 98.3 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар хэмнэлтийг тооцоолж, хэрэгжилтийг хянахад зайлшгүй биш зардал санхүүжигдээгүй бөгөөд, ажлын байр шинээр ашиглалтад ороход шаардлагатай зардлуудыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Цар тахал хорио цээрийн үед аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагаа хязгаарлалттай байснаас шалтгаалан үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгдөөгүй байна. Цаашид шинэ ажлын байранд хурал зөвлөгөөн, уншлагын уралдаан, бусад арга хэмжээг явуулах хэвийн нөхцөл байдал хангагдсан тул үйл ажиллагааны орлогыг үндэслэл сайтай төлөвлөж, төсвийн бүрэлдэхүүн хэсэгт батлах шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны 27 тогтоолын 4-р хавсралтад актлах хөрөнгийг данснаас хасахдаа 6 нэр төрлийн 135 ширхэг 11,348.5 мянган төгрөгийн хөрөнгө сумдын Соёлын төвд хандивлахдаа байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй, гардуулалт, тооцоо нийлсэн баримтгүй тарааж өгснийг аудитын явцад шаардаж, гардуулсан тооцоо нийлсэн баримт жагсаалтаар гаргуулж баримтжуулсан.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төв аймгийн Нийтийн номын санг 2020 онд Төв аймаг- БНСУлсын Пёнтөк хотын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Солонгос улсын Пёнтөк хотоос 920,000.0 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 276,000.0 мянган төгрөг, нийт 1,196,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засвар, шинэчлэлт хийхээр зураг төслийг ДИ ЭС ЖИ ХХК хийж, гүйцэтгэгч компаниар “Нумт өргөө” ХХК шалгарч их засварын ажлыг гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн байна.

ОНХО-аар 150,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын тендерт ЭБЭТ ХХК шалгарч тавилга тоног төхөөрөмж, шинэ номыг нийлүүлэхээр болсон. Үүнд: Агаар чийгшүүлэгч, ном ариутгагч, номын тавиурууд, сандал, хурлын танхимын төхөөрөмжүүд, шинэ ном, компьютер зэргийг танхимуудад байршуулсан байна.

“Цахим номын сан” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн 20,000.0 мянган төгрөгөөр Аймгийн засаг дарга, “Битлинк” ХХК-ын хооронд байгуулсан гэрээний дагуу цахим номын сангийн тоног төхөөрөмжийг аймгийн Нийтийн номын санд хүлээлгэн өгсөн. Үүнд: Ном баримт цахимжуулагч/ Документ скайнер/, зөөврийн компьютер, цахимжуулсан номын эхийг хадгалах төхөөрөмж /зөөврийн хард/, хард диск уншигч, цахим ном, цахим хуудас, ухаалаг дэлгэц зэрэг багтсан.

Соёлын яаманд хүсэлт тавьсны дагуу номын тавиур 6 ширхэг, уншигчийн ширээ 10 ширхэг, сандал 20 ширхэг, албан өрөөний ширээ 1 ширхэг, сандал 1 ширхэг, нийт 5,536.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж авсан.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь 140 мэдээлэл байршуулж, 9 мэдээлэл хугацаа хоцроож 97,0 хувьтай хэрэгжүүлсэн байна. Хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй талаар Төв аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний 21 тоот албан бичгээр төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Нийтийн номын сангийн заал танхимыг олон нийтийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаагаар үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөж төлөвлөгөөнд тусгаж, төвлөрүүлэхийг дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 23,199.8 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 4,157.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 2,858.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 16,184.4 мянган төгрөгийн материаллаг бус 3 зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Төсвийн гүйцэтгэлийн тайланд Нийт зардлыг болон санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 4,107.5 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй, нийт 4,107.5 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

ОБГ-с үнэ төлбөргүй ирсэн 500 ширхэг 50.0 мянган төгрөгийн маскийг тулган баталгаажуулалт хийхэд бараа материалын дансанд орлого авч зарлагдаагүй бөгөөд, “Ковид-19” цар тахлын үед ажилтнууддаа жагсаалтын дагуу зарлага болгож данс бүртгэлд тусгаагүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.3 Албан шаардлага

Орон тоог төлөвлөгөөтэй нь хянан үзэхэд 4 ээлжийн жижүүрийг ээлжийн амралттай байх хугацаанд орон тооны хүн авч ажиллуулан 2,858.0 мянган төгрөгийн цалин олговор олгосон, мөн 2 даргын ажил солилцсоны дараа ээлжийн амралтын олговор, цалин, ажиллах хугацаа давхардсан байдалтай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох,” гэсэнтэй нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг”, “Бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөлтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны 27 дугаар тогтоолын 4-р хавсралтад актлах хөрөнгийг данснаас хасахдаа 1 нэр төрлийн 220.0 мянган төгрөгийн 4ш үзэсгэлэнгийн тавиурыг актлахгүй тоолж, үлдээсэн байна. 6 нэр төрлийн 135 ширхэг 11,348.5 мянган төгрөгийн хөрөнгө сумдын Соёлын төвд хандивлахдаа байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй, гардуулалт, тооцоо нийлсэн баримтгүй тарааж өгсөн зөрчил байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 8.1-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж

авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", " Нийцсэн бөгөөд зохистой байх " гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

**Өгсөн зөвлөмж:**

Эрх бүхий байгууллагын шийдвэрийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлж, хариу тайлагнаж байх

**1.2. Илрүүлэлт:**

Аймгийн ИТХ-ын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны 27 дугаар тогтоолын 4-р хавсралтад актлах хөрөнгийг данснаас хасахдаа, өөрийн байгууллагын ажилтнуудад 24 ширхэг 2,474.6 мянган төгрөгийн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй, үнэ тогтоон 68.0 мянган төгрөг дансанд төлж, гардуулалт, үнэ тогтоосон баримтгүй тараасан зөрчил байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 8.1-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", " Нийцсэн бөгөөд зохистой байх " гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

**Өгсөн зөвлөмж:**

Эрх бүхий байгууллагын шийдвэрийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлж, хариу тайлагнаж байх

**2. Худалдан авалттай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:**

Худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулсныг тулгалт хийхэд, 3 байгууллагатай 2,361.3 мянган төгрөгийн гүйлгээг баримтжуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “НХМаягт ТМ-5 ebarimt -нд үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлээгүй” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", " эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрэн бүрдүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д /д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Нийтийн номын сан	6	23,199.8	2	4,157.4	0	0.0	1	2,858.0	3	16,184.4